

“МАК InternShip 2023” ЦАЛИНТАЙ ДАДЛАГАЖИХ ХӨТӨЛБӨР

Энэхүү хөтөлбөр нь дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд компанид хэрэгцээт мэргэжлээр суралцаж байгаа болон компанийн тэтгэлгээр суралцаж байгаа оюутнуудыг газар, алба үйлдвэр, уурхай, болон охин компаниудад дадлагажуулах, оюутан залуусыг ажлын гараанд зөв, системтэй бэлтгэх, ажлын бодит туршлага хуримтлуулах, өөрийгөө хөгжүүлэх болон байгууллагын соёлд суралцах олон боломжийг олгох зорилготой.

Тавигдах шаардлага:

- Монголын топ их, дээд сургууль /МУИС, ШУТИС, ХААИС, СЭЗИС гэх мэт/ МСҮТ болон коллежид /Герман Монголын хамтарсан МСҮТ, Барилгын политехник коллеж, Монгол Солонгосын политехник коллеж болон манай компанитай хамтран ажиллах гэрээтэй орон нутгийн МСҮТ-үүд/ суралцдаг байх
- Их дээд сургуулийн 3 болон 4-р дамжааны оюутан байх
- Тухайн оюутны сургуулиас батлагдсан дадлагын удирдамж
- Дадлага хийхийг хүссэн өргөдөл
- Суралцаж байгаа нь үнэн болохыг баталсан сургуулийн тодорхойлолт, дүнгийн хуудас
- Голч дүн 3.0 ба түүнээс дээш байх /4.0 хүртэлх томьёоллоор/
- Сурах хүсэл эрмэлзэлтэй, сурлагын амжилтаар тэргүүлэгч байх
- Сурлагын дүнгээс гадна нийгмийн хариуцлагын болон сайн дурын ажилд идэвхтэй оролцдог бол давуу тал болно
- Оюутны талаарх тодорхойлолт /Тухайн оюутны сурч буй сургуулийн 2-с дээш багшийн тодорхойлолт/
- Тэтгэлгийн сонгон шалгаруулалтанд тэнцэж дадлагажих боломжтой болсон оюутан Хөдөлмөр, хамгаалалтын хувцас хэрэгсэлтэй байх /safety гутал, ажлын хувцас/

Хөтөлбөрт шалгарсан оюутанд олгох боломжууд:

- Ажлын бодит туршлага хуримтлуулж, олон жилийн туршлагатай инженер, мэргэжилтнүүдээс зөвлөгөө авч, хүрээлээ тэлэх боломжтой.
- Компаниас зохион байгуулагдаж буй хувь хүний багц сургалтад хамрагдаж өөрийн суурь ур чадвараа дээшлүүлж, ажлын байранд өөрийгөө бэлтгэх
- Дадлагын хугацаанд зохих дүнгээр цалинжих

Дараах мэргэжлээр суралцаж буй оюутнууд хамрагдах боломжтой:

- Ус, дулаан хангамжийн инженер
- Химийн инженер, химич
- Автоматжуулалтын инженер
- Технологич инженер
- Төлөвлөлт, горимын инженер
- Барилгын материал технологийн инженер
- Уул уурхайн ашиглалтын болон хүнд машин механизмын инженер
- Дэд бүтэц, сэргээгдэх эрчим хүчний инженер
- Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн инженер
- Барилга, бүтээцийн инженер
- Халаалт, агаар сэлгэлтийн инженер
- Мэдээллийн технологийн инженер

Сонгон шалгаруулалтын үе шат

1. Материал бүрдүүлэлт
2. Ярилцлага

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ

1. Анкет (Цаасаар эсвэл цахимаар бөглөх боломжтой)
2. Цээж зураг (3x4 хэмжээтэй)
4. Их, дээд сургуулийн дүнгийн хуулбар- Сургуулийн сургалтын албанаас цохолт тамгатай албан бичиг
5. Гаргасан амжилт болон хичээлээс гадуур сайн дурын ажил хийснийг батлах материал - Улс, аймаг, хот, дүүргийн олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт, эсвэл урлаг, спортын чиглэлээр гаргасан амжилтыг баталгаажуулах материалын хуулбар (Үүнд зөвхөн сүүлийн 2 жил буюу 2021, 2022 онд гаргасан амжилтыг тооцно. Амжилтын хуулбарыг нотариатаар баталгаажуулах шаардлагагүй, огноо, нэр, үзүүлсэн амжилт тод харагдахуйц байх);
7. Сургуулийн тодорхойлолт, батлагдсан дадлагын удирдамж

Бүтээгч Монголын төлөө